



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 32 дугаар хуралдааны тэмдэглэлд:

XXXII.3.ХЭЛЭЛЦЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн Улсын үзлэг, тооллогын дүнгийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 481 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Засгийн газарт хүргүүлэх;

2. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн Улсын үзлэг, тооллогын дүнгээр илэрсэн 1 дүгээр хавсралтад заасан дутагдуулсан хөрөнгийн асуудлыг судлан шийдвэрлэж төрийг хохиролгүй болгох, 2 дугаар хавсралтад заасан маргаантай хөрөнгийн асуудлыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэхийг холбогдох төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал наарт, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, хяналт тавихыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс болон Хууль, эрх зүйн хэлтэст үүрэг болгох;

3. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Орон нутгийн өмчийн газарт тус тус даалгах нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

